



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 4/30

Чингис хот

Нэг цэгийн үйлчилгээний төвийн
нийгмийн ажилтны цалинд шаардагдах
хөрөнгийг шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.6, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны "Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 06 дугаар тогтоол, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны "Аймгийн 2021 оны төсөв батлах тухай" 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.4.10.2 дахь арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Нэг цэгийн үйлчилгээний төвийн нийгмийн ажилтны цалинд шаардагдах 15.000.000 /арван таван сая/ төгрөгийг аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт шилжүүлсүгэй.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Г.Лхагвахатан/-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010267